



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/148

Чойр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сүмбэр сумын “Энхтус дэм” өрхийн эрүүл мэндийн төвд хэрэгжүүлэх нийгмийн эгэх хариуцлагын тэтгэлэгт төслийн хүрээнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ж.Тунгалаг

(Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Т.Чимэд

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн бодлого хариуцсан мэргэжилтэн)


Д.Ариунаа

(Хотол Чойр иргэний нийгмийн байгууллагын гүйцэтгэх захирал)

2.Төслийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Ж.Тунгалаг)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (С.Уранцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТЗАМ